



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 8/44

Мандалговь

Г Зам тээврийн ослоос урьдчилан  
сэргийлэх ажил зохион байгуулах тухай

Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндэсэн чиглэлийн 1.3.4, 1.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. Төв аймгаас Дундговь аймгийн Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус, Хулд сумдын нутаг дахь хатуу хучилттай авто зам орчимд нутагладаг малчдад холбогдох хуулиар сургалт, сурталчилгаа хийх, тусгайлан бэлдсэн санамж тараах, бод малын хүзүүнд үзэгдэх орчин хязгаарлагдмал үед тээврийн хэрэгслийн гэрэлд гялбаж оих зориулалттай түузан хүзүүвч хийх ажлыг 2019 оны 1 дүгээр сарын 24-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

Хоёр. Дээрх ажлын удирдамжийг боловсруулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (О.Амарсанаа)-д, ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус, Хулд сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн 2019 оны 3 дугаар сарын 1-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтэс(Б.Түвшинбаяр)-д, Цагдаагийн газар(О.Амарсанаа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010116